



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/469

Ховд

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах,
түр түтгэлзүүлэх, цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.17.1, 19.20.2, 19.21 дэх заалтууд, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Булган сумын Өрхийн эрүүл мэндийн төв, “Цэлмэг ирээдүй” эмийн сан, “Сувдан шигтгээ”, “Энхрий жаргалан” шүдний эмнэлгүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр, Мэлмий оптик, Талст оптик хараа зүйн байгууллагуудын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр тус тус сунгасугай.

2. Өөрийн үйл ажиллагааны чиглэлээр нэр, хаягийг өөрчлүүлэх, ор нэмэх хүсэлт гаргасан Содон сондор шүдний эмнэлгийн хаягийг өөрчлөх, Алтан гагнуур эмийн санг Ачит алтан гагнуур ХХК нэр дээр шилжүүлэх, Мөнгөн морьт эмнэлэгт мэдрэлийн 5 ор нэмэх зэрэг өөрчлөлтүүдийг нэмэлтээр оруулж, Мөнхийн тун эм ханган нийлүүлэх байгууллага нь хүний нөөцөө хангаж ажилласан тул үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээсүгэй.

3. Өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлуулах хүсэлт гаргасан “Янзага” хүүхдийн эмнэлгийн үйл ажиллагааг цуцалж, мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад орон байр, тоног төхөөрөмжийн нөөц хангалтгүй Марал эмийн сангийн үйл ажиллагааг хугацаагүйгээр түтгэлзүүлсүгэй.

4.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан, түтгэлзүүлсэн, цуцалсан, нэмэлт өөрчлөлт оруулсан

Zax A/469 Ch

02 02090

байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ